

## НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

### 1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХАЯГ

Хаяг: Монгол улс, Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг

Утас: +976- 025-2454-3813

Факс: +976- 11-323-754

### 1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ


<b>Компанийн оноосон нэр:</b>	“Э-Транс Ложистикс” ХК
<b>Байгуулагдсан огноо:</b>	2010 он 12 сар
<b>Улсын бүртгэлийн дугаар:</b>	9019059011
<b>Регистрийн дугаар:</b>	3309665
<b>Газар эзэмших гэрчилгээний дугаар:</b>	00208339
<b>Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний дугаар:</b>	Ү-0711001097
<b>Нийт эзэмшдэг газрын талбайн хэмжээ:</b>	50,000 м2
<b>Үйл ажиллагааны үндсэн чиглэл:</b>	Ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа


### 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ

Үнэт цаас гаргагч компани нь 2010 оны 12 сард ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа эрхлэхээр 4 гишүүнтэйгээр үүсгэн байгуулагдсан. Компани 2011 оны 02 сард үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор 100 төгрөгний нэрлэсэн үнэтэй 38,490,000 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган үүсгэн байгуулагч “Монголиан Транспортэйшн Холдинг” ХХК, “БиДиПиИЭф” ХХК, Х.Батхишиг нар мөнгөн хөрөнгөөр, “Э-Транс” ХХК нь ачаа шилжүүлэн ачих цогцолборын эд хөрөнгөөр хувьцаа худалдан авч дүрмийн санг 3,850,000,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.

Компани хөрөнгө оруулалтын үр дүнд “Э-Транс” ХХК-аас терминалын үлдсэн эд хөрөнгийг худалдан авснаар Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах ачаа шилжүүлэн ачих терминалын хөрөнгө, үйл ажиллагааг бүрэн шилжүүлэн авсан. Улмаар 2011/03/01-ны өдрөөс ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагааг эхлүүлэн амжилттай ажиллаж байна.

Уг шилжүүлэн ачих терминалын төслийг “Э-Транс” ХХК 2007 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2009 онд ашиглалтанд оруулж байсан.





### 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ

#### **Компанийн үндсэн үйл ажиллагаа**


Үнэт цаас гаргагчийн ачаа шилжүүлэн ачих цогцолбор /терминал/ нь Монгол улсыг Хятадтай холбосон хамгийн том боомт болох Замын-Үүд боомтод 5га талбайд үйл ажиллагаа явуулж Хятад улсаас ачааны машинаар тээвэрлэгдэн импортоор ирж буй ачааг вагонд, вагоноор ирж буй ачаа барааг ачааны машинд шилжүүлэн ачих үйлчилгээ үзүүлдэг.


Терминал нь хилийн хаалганаас 100м зайд байрлан үйл ажиллагаа явуулдаг ба энэ нь хэрэглэгчдийн хувьд маш тохиромжтой байрлал юм. Үйлчлүүлэгчид БНХАУ-аас оруулж ирж буй бараа бүтээгдэхүүнээ терминалд хүлээлгэн өгснөөр түүнийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт өөр бусад хүссэн газраасаа хүлээн авах боломжтой байдаг.

Компанийн удирдлагын багийн гишүүд тээвэр зууч, төмөр замын салбарт олон жил ажилласан туршлагатай боловсон хүчнээс бүрддэг. Сүүлийн жилүүдэд МУ-н ачаа эргэлт тасралтгүй өсч байгаатай холбоотойгоор терминалын эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Компанийн тохиромжит байрлал, ур чадвартай менежмент, хамтран ажиллах тааламжтай нөхцөл зэрэг нь үндсэн гол давуу талуудыг бий болгодог.

Терминал нь төмөр замын 2 салаа тус бүр нэг удаад 17 вагон, сард 600 вагонд ачилт хийх, жилд 1000.0 мян.тонн ачааг шилжүүлэн ачих хүчин чадалтай.

Үнэт цаас гаргагч нь шилжүүлэн ачих хугацааг бууруулах, ажиллах хүч хэмнэх, үйл ажиллагааг хялбарчлах, хүчин чадлыг нэмэгдүүлэх үүднээс төрөл бүрийн ачаа шилжүүлэн ачих дамжуурга, механикжуулалтыг нэвтрүүлж байна.





2012-01-18 өдөр

БҮРТГЭВ "Э-Транс Ложистикс" ХК

№ 01

Үнэт цаасны танилцуулга


### Гаалийн хяналтын бүс

Үнэт цаас гаргагчийн шилжүүлэн ачих зориулалт бүхий 5 га талбайд гаалийн хяналтын бүс байрладаг. Тус хяналтын бүсэд Гаалийн хяналтын бүс тогтоох тухай Гаалийн ерөнхий газрын даргын 2010/09/21-ны өдрийн №475-р тоот тушаалаар зөвшөөрөл олгосон.

Үнэт цаас гаргагчийн талбайд байрлах Гаалийн хяналтын бүс нь 2011/04/01-ээс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд үйлчлүүлэгчдийн ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагааг хөнгөвчлөх үүднээс нэг цэгийн үйлчилгээ үзүүлж, дараах байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.


1. Монгол улсын гааль
2. Мэргэжлийн хяналтын газар
3. Банк
4. Гаалийн бүрдүүлэлтийн зууч

Тус гаалийн хяналтын бүсээр нэвтэрч буй бараа бүтээгдэхүүний экспортлогч болон импортлогчид нь гаалийн бүрдүүлэлт хийх, Монгол улсын гаальд хянуулах, Мэргэжлийн хяналтын газраар шалгуулах, татвар хураамжаа банкинд тушаах зэрэг үйлчилгээг нэг дороос авах бөгөөд Монгол улсын гаалиар нэвтэрсний дараа шууд тус талбай дээрээ Үнэт цаас гаргагчийн ачаа шилжүүлэн ачих үйлчилгээг авах боломжтой байдаг.



Зураг 1 Хяналтын камерын байршил

Талбайд 4 ширхэг хяналтын камер 15метрийн өндөрт байрлан ачилт буулгалтын талбайг бүрэн хяналтандаа байлгадаг. Талбайн гэрэлтүүлэгт 400BT 14 ширхэг, 500BT 4 ширхэг, нийт 18 ширхэг 400BT-500BT гэрлүүдийг байрлуулан талбайг бүхэлд нь гэрэлтүүлж байна.





СЭХ  
2012 оны 01 сар 18 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

"Э-Транс Ложистикс" ХК

Үнэт цаасны танилцуулга


### Хяналтын камер нь



Зураг 3 Хяналтын камер


250 метрийг татах хүчин чадалтай, дээш доошоо 45 градус хазайн 355 градус эргэдэг, бичлэгийг 30 хоног хадгалж чадах 500GB багтаамжтай камеруудыг 15 метрийн өндөрт талбайг бүхэлд нь хянахаар байрлуулсан.

### Зөөврийн авто пүү




Зураг 4 Зөөврийн авто пүү

150 тоннын дижитал авто пүү дээгүүр автомашин 3-5 км цагийн хурдтай гарахад тэнхлэг тус бүрээр нь пүүлж нийт жинг тогтоож гаргадаг.



СЭХ  
2012 оны 01 сар 18 өдөр  
БҮРТГЭВ "Э-Транс Ложистикс" ХК  
№ 01  
Нүүрс шилжүүлэн ачилт

Үнэт цаасны танилцуулга



Ачаа шилжүүлэн ачилт



Ачаа шилжүүлэн ачилт



3309885 ГСТ1645  
Э-ТРАНС  
ЛОЖИСТИКС  
ХХК  
ДОРНОГОВЬ АЙМАГ

УЛААНБААТАР  
Б. А. А. А.

СЭХ  
2012 о-01 сар 18 өдөр  
БҮРТГЭВ "Э-Транс Ложистикс" ХК  
№ 01

Үнэт цаасны танилцуулга

Тус бүр 3200 м кв бүхий 3 түр агуулах



Нэг цэгийн үйлчилгээний оффисын барилга




Монгол улсын гааль



XXK  
ДОРНОГОВЬ АЙМАГ


Handwritten signature and stamp area.



**Дэд бүтэц**

Терминал нь авто зам, төмөр замаар олон улс болон Монгол улсын томоохон хот сууринтай холбогдсон газар зүйн өндөр ач холбогдол бүхий бүсэд байрладаг.

- Төвийн нэгдсэн цахилгаан эрчим хүчинд холбогдсон, өөрөө бие даан цэвэр бохир ус, дулаан хангамжийг шийдсэн
- Утас интернет зэрэг цахилгаан холбоо банк санхүүгийн үйлчилгээгээр бүрэн хангагдсан.
- 350 м урт төмөр замын 2 салаа,
- Тус бүр нь 1500м2 талбайтай 2 агуулах, ажилчдын байр, түр оффис, гаалийн хяналтын газар
- Нийт 5 га талбай болон бусад дэд бүтцээр бүрэн хангагдсан.





СЭХ  
 2010 оны 01 сар 18 өдөр  
 БҮРГЭЭВ "Э-Транс Логистикс" ХК  
 № 01

1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БАЙРШИЛ

Ачаа шилжүүлэн ачих терминал



Дорноговь аймаг  
 Замын-Үүд өртөө.



3309065 ГСТ1645  
 Э-ТРАНС  
 ЛОЖИСТИКС  
 ХХК  
 ДОРНОГОВЬ АЙМАГ

Зураг 5 Терминалын байршил

УЛААНБААТАР ХОТ  
 ИХБ-ийн галзуур  
 Алдсүрэйтөр  
 Б. Мунд